

Монголын Бэлчээрийн Менежментийн Холбооноос санаачлан **"Бэлчээрийн эрхэвн орчинг боловсронгуй олгох асуудалд"** **6**

сэдэвт бага хурлыг УИХ-ын Байгаль орчин, Хvнс, Ходоо Аж Ахуйн байнгын хороо, Хvнс, Ходоо Аж Ахуй, Хонгон Үйлдвэрийн Яам, "Тогтвортой Амьжиргаа 2", "Ногоон Алт", "Хот орчмын бэлчээрийн" тосолтэй хамтран 2010 оны 10 дугаар сарын 21-нд Улаанбаатар хотноо торийн ордонд зохион байгуулав. Бага хуралд 21 аймгийн малчид, торийн ба ТББ-ын толоолол 500 орчим толоологчид оролцлоо.

Монгол орны бэлчээрийн толов байдал, даац жилээс жилд доройтсоор манай улсын эдийн засаг, нийгмийн тогтвортой байдалд сорог нолоо vзvvлж байна. Мал хувийн эзэмшилд, бэлчээр торийн мэдэлд байгаагаас бэлчээрийг дур зоргоороо, эмх замбараагвй ашиглаж буй байдал нь энэхvv доройтолд нолоолж байгааг сvvлийн вейн судалгаа нотолж буй.

Бэлчээрийн зохион байгуулалт туйлын хангалтгvй, тороос энэ талаар нэгдсэн бодлого, шийдвэр гаргаагвй байгаа нь нохон сэргээгддэг байгалийн внэт их баялаг "БЭЛЧЭЭР" талхлагдаж дахин сэргэхгvй болтол доройтоход хvргэж байна. Малчны оорийгоо удирдах байгууллагын тогтолцоог бий болгон бэхжvvлж бэлчээрийг эзэнтэй болгон бэлчээр зохион байгуулалтын асуудлыг оновчтой шийдвэрлэхэд бие даасан хууль гаргах зайлшгvй шаардлагатай байгаа учраас УИХ-д оргон баригдсан Бэлчээрийн тухай хуулийн тослийг хэлэлцvvлэх, цаашлаад батлах амин чухал шаардлагатай гэдэг дээр хуралд оролцсон толоологчид санал нэгдэж байлаа.

Бага хурлаас бэлчээрийн талаар баримтлах торийн бодлогыг тодорхой болгох, малчдын оорийгоо удирдах байгууллагын тогтолцоог бvрдvvлэхэд чиглэгдсэн "Малчдын талаар тороос баримтлах бодлого"-ыг хэрэгжvvлэх арга замыг тодорхойлох, оргон баригдсан хуулийн vзэл санаа, заалтуудыг хэлэлцэн ашиглагчдын санал, бодлыг тусгаахаар хэлэлцvvлэг зохион байгуулж зовломж гаргалаа.

Хуралд оролцогчид бэлчээрийн талаар тороос баримтлах зарчим, бэлчээрийн ангилал, хил зааг, эзэмших ашиглах эрх, малчдын оороо удирдах байгууллага, тvvний эрх хэмжээ, бэлчээрийн толбор, урамшуулал болон хариуцлагын тогтолцоог нарийвчлан зохицуулах шаардлагатай гэсэн санал гаргаж, зовломж боловсруулан хуулийн тосол санаачлагчдад хvргvvлэв.

Монгол орны ходоогийн хогжлийг дэмжих, байгалийн нооцийг тогтвортой ашиглах, бэлчээр хамгаалах, газрын тогтвортой менежмент бvрдvvлэх, цолжилтийг бууруулахад чиглэлээр торийн оновчтой бодлого, шийдвэр гаргах, малчдын сайн дурын байгууллагын оролцоог бодлого, толовлолтод нэмэгдvvлэхэд уг бага хурлаас гарсан зовломж ихээхэн ач холбогдолтой юм.

{slide=Бага хурлын эмхэтгэл}{pdf}images/pdfbook/nogoonalt/law/Baga hurliin Emhetgel.pdf{/pdf}/{/slide}

{slide=Хуралд оролцогчдоос гаргасан зовломж}{pdf}images/pdfbook/nogoonalt/law/Baga hurlaas gargasan zovlomj.pdf{/pdf}/{/slide}

